



2025 оны I улирлын санхүү, үйл ажиллагааны тайлан

"ЛэндМН ББСБ" ХК



Агуулга

01

Бизнесийн үйл
ажиллагаа

02

Санхүүгийн
үзүүлэлтүүд

03

Онцлох
үйл явдлууд



2025 ОНЫ I УЛИРЛЫН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ

Дижитал бизнесийн зээлээ бизнес эрхлэгч нартаа илүү хүртээмжтэй болгож ажиллалаа

“ЛэндМН ББСБ” ХК нь технологийн шийдлээр дамжуулан хүртээмжтэй санхүүжилтийг түгээх эрхэм зорилготой ажилладаг билээ. Энэхүү зорилгын хүрээнд бид олон шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд амжилттай нэвтрүүлж, хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлсээр байна.

2024 онд бид Монгол Улсад анх удаа бизнесийн зээлийг гар утсаараа 5 минутын дотор, барьцаагүй, бүрэн дижитал хэлбэрээр авах боломжийг бий болгосон нь томоохон дэвшил байлаа. Уг бизнесийн зээлийн шийдэл нь харилцагчийн хүсэлтийг хүлээн авсан даруйдаа, AI-д суурилсан кредит скорингийн аргачлалаар бодит цагийн горимд боловсруулж, харилцагчдад үр дүнг шууд мэдээлэн ажилладгаараа онцлогтой.

Бид уг Flexi Business зээлийн бүтээгдэхүүнээ зах зээлд нэвтрүүлээд 10 сар гаруй болж байгаа бөгөөд энэ хугацаанд нийт 123 мянган харилцагчид бизнесийн зээлийн хүсэлт илгээсэн байна. Энэ нь зах зээл дээр маш олон бизнес эрхлэгчдэд энэхүү зээлийн үйлчилгээний хэрэгцээ байгааг, мөн тэднийг илүү хүртээмжтэйгээр хамруулах боломжуудыг нэмэгдүүлэх хэрэгтэй гэдгийг харуулж байна.

2024 оны IV улиралд зээлийн багцын 23 хувийг Flexi Business зээлийн бүтээгдэхүүн бүрдүүлж байсан бол 2025 оны I улиралд энэ тоо 26 хувьд хүрч өслөө. Уг хугацаанд нийт

14.2 мянган удаагийн олголтоор 51.4 тэрбум төгрөгийн зээлийг бизнес эрхлэгчдэд олгоод байна. Бидний уг бизнесийн зээлийн бүтээгдэхүүнээрээ дамжуулан бий болгож буй гол үнэ цэнүүдийн нэг нь барьцаа хөрөнгийн шаардлагыг хангахгүйгээс зээл авах боломжгүй байсан бизнес эрхлэгч нартаа хүсэлт гаргасан тухайн агшинд зээлийн боломжит хэмжээгээ харж, тэр даруй санхүүжилтээ авах боломжийг бий болгосон явдал юм.

Бид мөн бичил болон өрхийн бизнес эрхлэгчдийг дэмжих үүднээс Flexi Business зээлийн доод хэмжээг 5 сая төгрөг байсныг 500 мянган төгрөг болгон буурууллаа. Ингэснээр бизнес эрхлэгчид маань өдөр тутмын бараа татан авалтын хэрэгцээгээ ч Flexi Business зээлээр шийдэж, эргэн төлөлтөө өөрийн бизнест ачаалал багатайгаар, урт хугацаанд хуваан төлөх боломжтой болж байгаад баяртай байна.

Монгол улсынхаа эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмрээ оруулж буй бичил бизнес эрхлэгч харилцагч нарынхаа бизнесийн эргэлт, борлуулалтыг дэмжих зорилгоор бид тун удахгүй худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчдэдээ зориулан тэдний борлуулалт, эргэлтийг дэмжсэн шинэ төрлийн бүтээгдэхүүнээ 2025 оны II-р улиралд танилцуулахаар бэлтгэл ажлаа хангаад байна.

Flexibusiness

доод
хэмжээ

500 мянга



дээд
хэмжээ

100 сая ₮ хүртэл

ЭРХ ТООЦООЛОХ →

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Санхүүгийн үзүүлэлтүүд өмнөх онуудын мөн үетэй харьцуулсан байдлаар



Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /Нэгтгэсэн/

Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /тэрбум төгрөг/	2023.I	2024.I	2025.I
Нийт орлого	9.7	17.9	28.8
Хүүгийн зардал	(2.2)	(3.9)	(7.7)
Цэвэр орлого	7.5	14.0	21.1
Зээлийн үйл ажиллагаатай холбоотой зардал	(1.3)	(0.9)	(0.9)
Зээлийн болзошгүй эрсдэлийн нөөцийн зардал	(0.7)	(1.5)	(4.5)
Үйл ажиллагааны цэвэр орлого	5.5	11.6	15.7
Удирдлагын болон үйл ажиллагааны зардал	(0.9)	(2.1)	(3.4)
Татварын өмнөх ашиг	4.6	9.5	12.3
Татварын зардал	(0.9)	(2.3)	(2.5)
Цэвэр ашиг	3.7	7.2	9.8

Санхүү байдлын хураангуй тайлан /Нэгтгэсэн/

Хөрөнгө /тэрбум төгрөг/	2023.I	2024.I	2025.I
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	4.3	9.6	11.5
Зээлийн багц (цэвэр)	73.7	154.1	250.4
Бусад хөрөнгө	2.6	0.6	2.8
Үндсэн хөрөнгө	0.5	1.3	4.8
Биет бус хөрөнгө	0.4	0.3	0.7
Нийт хөрөнгө	81.5	165.9	270.2

Өр төлбөр болон эздийн өмч /тэрбум төгрөг/	2023.I	2024.I	2025.I
Өр төлбөр	53.6	116.0	187.4
Эх үүсвэр	40.8	90.0	169.1
Хоёрдогч өглөг	2.8	2.8	2.8
Бусад өглөг	10.0	23.2	15.5
Эздийн өмчийн дүн	27.9	49.9	82.8
Хувьцаат капитал	8.5	8.5	8.5
Хуримтлагдсан ашиг	19.4	41.4	74.3
Нийт өр төлбөр болон эздийн өмч	81.5	165.9	270.2

КОМПАНИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

ЛэндМН нь дэлхийд жишиг тогтоолоо

“ЛэндМН ББСБ” ХК нь Олон Улсын Үнэлгээний MFR Global Rating Agency-с “Харилцагчийг Хамгаалах Сертификат” авсан дэлхийн анхны финтек компани боллоо.

Micro Finance Rating (MFR) Олон Улсын Үнэлгээний Байгууллага нь санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг шударга, ил тод байдлын 8 үндсэн зарчмын дагуу үнэлж Алт, Мөнгө, Хүрэл түвшинд ангилдаг бөгөөд ЛэндМН нь Мөнгөн түвшний стандартыг хангаж, гэрчилгээгээ албан ёсоор авснаар финтекийн салбарт энэхүү гэрчилгээг авсандэлхийн анхны тохиолдол болж, шинэ жишгийг тогтоогоод байна.

“ЛэндМН ББСБ” ХК 2018 онд Монголын Хөрөнгийн Биржид бүртгэгдсэн бөгөөд анхдагч, финтек салбарын тэргүүлэгч гэдгээ дахин нотлон ийнхүү санхүүгийн салбарт жишиг тогтоон олон улсын стандартад нийцүүлэн харилцагчийн эрх ашгийг хамгаалж, ил тод нээлттэй байж, санхүүгийн боловсрол олгож, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэн ажиллаж буй нь хөрөнгө оруулагчдад болон нийт харилцагчдадаа ээлтэй чухал үйл явдал байлаа.

“Харилцагчийг Хамгаалах сертификат” нь Банк болон Санхүүгийн Байгууллагууд дараах 8 зарчмыг баримтлан ажилладаг болохыг баталсан олон улсын стандарт юм.

- Уг стандартад,
1. Харилцагчдад тохирсон бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх;
 2. Харилцагчийг хэт их өрийн дарамтаас хамгаалах;
 3. Ил тод байдлыг эрхэмлэх;
 4. Бодит үнийн бодлого баримтлах;
 5. Харилцагчтай шударга, хүндэтгэлтэй харилцах;
 6. Харилцагчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах;
 7. Харилцагчийн гомдлыг хүлээн авч, түргэн шуурхай шийдвэрлэх;
 8. Засаглал болон хүний нөөцийн зохистой бодлого баримтлах гэсэн үзүүлэлтүүдийг хангах ёстой байдаг.

ЛэндМН нь энэхүү стандартад заасан бүхий л шалгууруудыг ханган ажиллаж байна. Мөн ЛэндМН нь 2024 онд Сингапурын Төв Банк болон Сингапурын Финтек Холбооноос хамтран олгодог “Fin-tech Excellence Awards”-ийн Financial Inclusivity төрөлд эцсийн шатанд шалгарч байсан бөгөөд энэ удаад “Харилцагчийг Хамгаалах Сертификат” авснаар олон улсын байгууллагуудтай адил түвшинд тасралтгүй ахиж, дэлхийн жишигт нийцсэн хариуцлагатай санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч гэдгээ нотлон харууллаа.

ЛэндМН-тэй хамтдаа дараагийн шат руу алхаж, санхүүгийн салбарын бас нэгэн түүхэн үйл явдлын эзэд болсон нийт харилцагчдадаа талархал илэрхийлье!



Хувьцаа Эзэмшигчдийн Хурал

“ЛэндМН ББСБ” ХК нь Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа 8 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа.

“ЛэндМН ББСБ” ХК нь 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдөр Галлериа Улаанбаатар төв (Galleria Ulaanbaatar Center)-ийн 3 давхарт байрлах Juulchin Grand Ballroom танхимд зохион байгуулсан ба Хуралд нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 81.64% буюу 603,574,846 ширхэг хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид оролцсоноор тус хурал хүчин төгөлдөр болсон бөгөөд дараах асуудлуудыг хэлэлцэж баталсан юм.

Үүнд:

- Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлан;
- Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт;
- ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлан;
- Компанийн ТУЗ-ийн гишүүдийгулируулан сонгох;
- ТУЗ-ийн 2025 оны төсөв;
- Компанийн Дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлт;

Ногдол ашиг

“ЛэндМН ББСБ” ХК (MSE:LEND) нь нээлттэй компани болсон цагаасаа эхлэн 8,000 гаруй хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг хамгаалж, тогтмол ногдол ашиг хүртээх, мөн нээлттэй, ил тод байхад үргэлж анхаарч ирсэн билээ. Түүнчлэн, бид хувьцаа эзэмшигчдийнхээ санал бодлыг чөлөөтэй хүлээн авч, үйл ажиллагаандаа тусган, цаашдын зорилго, зорилтдоо хэрэгжүүлэн ажиллахыг эрмэлздэг.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлаас компанийн 2024 оны жилийн эцсийн цэвэр ашгаас Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 15 (арван таван) төгрөгөөр тогтоож, 2024 оны цэвэр ашгийн 30.62 (гуч зууны жаран хоёр) хувийг буюу 11,089,525,245 (арван нэгэн тэрбум наян есөн сая таван зуун хорин таван мянга хоёр зуун дөчин тав) төгрөгийн ногдол

ашгийг хувьцаа эзэмшигчдэдээ мөнгөн хэлбэрээр хуваарилахаар шийдвэрлэсэн юм.

Тус ногдол ашгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс ногдол ашиг авах эрхтэй компанийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдөр байхаар тогтоосны дагуу нийт 8,575 (давхардаагүй тоогоор) хувьцаа эзэмшигчдийн дансанд 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар дамжуулан олгоод байна.

Технологиор дамжуулан бүгдэд нээлттэй, гэгээлэг маргаашийг хамтдаа бүтээх зорилготой бидний үйл ажиллагааг үргэлж дэмжиж байдаг нийт хувьцаа эзэмшигчид, эрхэм түншүүд, үнэнч харилцагчид Та бүхэндээ талархлаа илэрхийлье.



“ЛэндМН ББСБ” ХК
Нэгж хувьцаанд
15 төгрөгийн ногдол ашиг
ОЛГОЛОО



ВЕБ САЙТ:

www.lend.mn

УТАС:

7707-0101

И-МЭЙЛ:

board@lend.mn

2025 оны I улирлын санхүү, үйл ажиллагааны тайланг бэлтгэсэн:
Маркетингийн хэлтсийн менежер Б.Батбилэг
Хянасан: Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр